

“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

2015 оны 4 дүгээр сарын 28

№ 01

Улаанбаатар хот

“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4-р сарын 28-ны өдрийн 10 цагт “Шивээ-Овоо” ХК-ийн төлөөлөгчийн газарт боллоо.

Хурлыг нээж Эрдэнэс Монгол ХХК-ийн тэргүүн дэд захирал Б.Ариунболд үг хэлэв.

Б.Ариунболд: Эрдэнэс ХХК-аас олгосон удирдамжын дагуу “Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна хурлын ирцийг тооллогын комисс мэдээлье.

Г.Боргил: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. “Шивээ-Овоо” хувьцааткомпанийн 13419101 ширхэг хувьцааг эзэмшигч 1644 хувьцаа эзэмшигчдээс өнөөдрийн хуралд 13214927 ширхэг хувьцааг эзэмшдэг 5 хувьцаа эзэмшигч оролцож байна хурлын ирц 98,47 хувь байна.

Б.Ариунболд: Ирц хангалттай тул хурлаа эхлэе. Эхлээд хурлын дэгийг танилцуулья. /Дэгийг уншиж сонсгов./ Хурлын дэгийг батлах уу? Татгалзаж түтгэлзсэн хүн байна уу?

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид хурлын дэгийг санал нэгтэй батлав.

Б.Ариунболд: Дэгийг баталлаа одоо хурлын дэгийн дагуу хуралд оролцогчдыг танилцуулна уу?

Г.Боргил: Эрдэнэс Монгол ХХК-ийг төлөөлж тус хуралд оролцохоор итгэмжлэгдсэн Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, Зам тээврийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, Эрдэнэс Монгол ХХК-ийн тэргүүн дэд захирал Б.Ариунболд, газрын захирал Д.Болд, хуулийн зөвлөх О.Чинхүсэл, мэргэжилтэн Ж.Батбаяр, Шивээ-Овоо ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Д.Батсүх, Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар, Ерөнхий нягтлан бодогч С.Одбаяр, компанийн хувьцаа эзэмшигч Жеймс Пастон, М.Банзар, А.Чулуун, Стандарт инвест компанийн төлөөлөл Ц.Чимгээ нарын зэрэг хүмүүс хуралд оролцохоор ирсэн байна. Мөн Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн албаны мэргэжилтэн н.Амартүвшин ажиглагчаар оролцож байна.

Б.Ариунболд: Хурлын дэгийн дагуу одоо хурлын тэргүүлэгчид болон нарийн бичгийн дарга, редакцийн комисс зэргийг сонгох ёстой. Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, Зам тээврийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, Эрдэнэс Монгол ХХК-ийн захирал Б.Бямбасайхан нарыг “Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулахаар итгэмжилсэн. Хурлын даргаар Х.Ганцогтыг томилсон байгаа. Б.Бямбасайхан захирал намайг өөрийн өмнөөс хуралд орцуулахаар бичгээр итгэмжлэх олгосны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн тэргүүн дэд захирал

Б.Ариунболд миний бие энэ хуралд оролцож байна. Хурлын тэргүүлэгчдээр Эрдэнэс Монгол ХХК-иас итгэмжилсэн 3-н төлөөлөгчийг, нарийн бичгийн даргаар Эрдэнэс Монгол ХХК-ийн хуулийн зөвлөх О.Чинхүсэлийг, редакцийн комиссоор Ж.Батбаяр, С.Одбаяр нарыг сонгох санал оруулж байна. Хуулийн дагуу хурлын тооллогын комиссыг танилцуулья. Тооллогын комиссыг Д.Батмөнх, Г.Борбил, Д.Ганбаатар гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ТУЗ-ийн 2015 оны 3-р сарын 18-ны тогтоолоор томилсон. Д.Батмөнх өвчтэй тул Эрдэнэс Монгол ХХК-ийн уул уурхайн газрын дарга Д.Болдыг тооллогын комисст нөхөн сонгох саналтай байна.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар Х.Ганцогт, Ж.Бат-Эрдэнэ, Б.Ариунболд нарыг хурлын тэргүүлэгчдээр, нарийн бичгийн даргаар Эрдэнэс Монгол ХХК-ийн хуулийн зөвлөх О.Чинхүсэлийг, редакцийн комиссоор Ж.Батбаяр, С.Одбаяр нарыг, тооллогын комисст Д.Болдыг тус тус сонгов.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд

Х.Ганцогт: Хурлын нарийн бичгийн дарга хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулья

О.Чинхүсэл: "Шивээ-Овоо" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулья.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлын тайланг сонсож үнэлэлт, дүгнэлт өгөх.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын гүйцэтгэлийг хэлэлцэх, 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хэлэлцэж батлах.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох гэсэн үндсэн 4 асуудал хэлэлцэнэ.

Х.Ганцогт: Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.Батболдын бичгээр олгосон итгэмжлэлийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Д.Батсүх танилцуулна.

Ж.Батболдын итгэмжлэхийг уншиж танилцуулав.

1 дүгээр асуудал:

Хэлэлцсэн нь:

Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Тэмдэглэсэн нь:

Д.Батсүх: Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт материалд дэлгэрэнгүй тараагдсан тул товч танилцуулья.

“Шивээ-Овоо” хувьцаат компани нь 2014 оны санхүүгийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд нь гарган зохих тайлбар тодруулгын хамт Санхүүгийн Олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалаар мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу гарган санхүү, татварын байгууллага болон холбогдох бусад газруудад тушаажээ.

“Шивээ-Овоо” хувьцаат компани 2014 онд 6,774,8 мян.м³ хөрс хуулж төлөвлөгөөг 82,1хувиар, 1,939.1мян.тонн нүүрс олборлож төлөвлөгөөг 97,0 хувиар, 2,013.7мян.тонн нүүрс борлуулж төлөвлөгөөг 100.7 хувиар тус тус биелүүлсэн байна.Нүүрс олборлолтын төлөвлөгөө 60,9 мян. тонн-оор тасарч борлуулалтын төлөвлөгөө 13,7 мян. тонн-оор давж биелэсэн байна.

Нийт борлуулалтын орлого төлөвлөсөн хэмжээнээс 0,9 хувь тасарсан ч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14,0 хувь буюу 4.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2014 онд бизнес төлөвлөгөөгөөр нийт 36,556,5сая төгрөгийн борлуулалт хийж 43,739.9 сая төгрөгийн зардал гарган 7,183,3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөгдсөн.

2014 онд 36,163.6 сая төгрөгийн орлого олж, 41,702,2 сая төгрөгийн зардал гарган 4,986.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, төлөвлөгөөт алдагдлыг 30,5 хувь буюу 2,197,3, сая төгрөгөөр бууруулсан байна.

Гэвч нүүрсний илчлэгийн зөрүүгээс 524,1 сая төгрөгийн орлого олох боломжоо алдсан байна.

Цаацид олборлолт, борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх замаар зардлыг нэмэгдүүлэх зохистой харьцааг хатуу барьж ажиллах шаардлагтай байна.

Нүүрсний өөрийн өртгийг бүрдүүлж буй зардлуудаас вагон ашиглалтын зардал, үл хөдлөх хөрөнгийн татвар, ус ашигласны төлбөр, элэгдлийн зардал, гэрээт ажлын хөлс, богино хугацаат зээлийн хүү, талбай ашигласны төлбөр зэрэг зардлууд дүнгээрээ 4,410,2 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Тэсрэх материал, дизель түлш, тос тослогооны материал, бензин шатхуун, дугуй сэлбэг, цахилгаан эрчим хүч зэрэг зардлуудаас 8,135,5 сая төгрөг хэмнэж нийт дүнгээрээ 3,725,3 ая төгрөгийн зардал төлөвлөснөөс хэмнэсэн тооцоо гарч байна.

Нийт эргэлтийн хөрөнгийн 28 хувийг авлага эзэлж байна. Авлагын эргэц удаан байгаа нь анхаарах асуудал юм..

Нийт авлага оны эхэнд 5,004.1 сая төгрөг байсан бол оны эцэст 7,586.0 сая төгрөг болж 15,1 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс ДЦС-4 ХК-ниас авах авлага оны эхэнд 2,771,6 сая төгрөг байсан бол оны эцэст 5,407,5 сая төгрөг болж өссөн байна. Нийт авлагын 70.0 гаруй хувийг ДЦС-4 ХК-наас авах авлага эзэлж байна. "Бор Өндөр УБҮ", "Налайх ДС", "Сэлэнгэ ЭХНҮ", "Төв Чандмань УҮГ", "Ус ДУ ХК" болон хувь хүмүүсээс авах авлагыг оны эхнээс зохих хэмжээгээр бууруулсан байна.

Нийт 86.6 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаагаас урт хугацаат өр төлбөр 55.3 тэрбум, богино хугацаат өр төлбөр 31.3 тэрбум төгрөгийн өглөгтэй байна.

Богино хугацаат өглөг цэвэр авлагаас 4,1 дахин их болж байгаа нь цаашид үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд бэрхшээл учруулж болзошгүй байна.

-Үндсэн хэрэглэгч ДЦС-4 ХК нь нүүрсний төлбөрөө сарын турш жигд төлж чадахгүй байгаагаас болон олборлосон нүүрсээ өртгөөс нь доогуур үнээр борлуулж байгаа зэргээс шалтгаалан уурхайн санхүү, төлбөрийн чадвар хүндэрч, төлөвлөсөн хөрөнгө оруулалт, ТЗБАХ-нд тусгагдсан их болон агергат засвар, тоног төхөөрөмжүүдийн шинэчлэлийг хугацаанд хийж чадахгүй байгаа нь үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Хөрс хуулалтын алдагдлыг нөхөх, олборлолт, борлуулалтыг нэмэгдүүлэх удирдлага зохион байгуулалтын оновчтой арга хэмжээ авч өртөг, зардлыг аль болох хямдруулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Гүйцэтгэх удирдлага авлага барагдуулах ажлыг ажил хариуцсан хүмүүсийн хариуцлага сахилга баттай холбон ажлын нь үр дүнг тооцох талаар хатуу шаардлага тавьж ажиллах нь чухал байна.

- Сангийн яамны шийдвэрээр НИК, Петровис тос, Содмонгол, компаниудад төлөх өглөг 2,4 тэрбум төгрөг, АМНАТ, талбай ашигласны 3 жилийн төлбөр 2,2 тэрбум төгрөг нийт 4,6 тэрбум төгрөгийг хаалтаар хойшлуулсан байна. Энэ шийдвэр нь уурхайн мөнгөн урсгалд нааштай нөлөө үзүүлсэн байна. Энэ байдлаас дүгнэлт хийхэд санхүү, төлбөрийн чадвар хүнд байдалд орж бие даалтын түвшин хасах тал руу явж байна. Нүүрсний илчлэгийн зөрүүгээс алдаж байгаа алдагдлыг арилгах, нүүрсний чанарыг дээшлүүлэх техник технологийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь чухал байна.

Цаашид эрчим хүчний зориулалттай нүүрсний үнийг өртөгт нь хүргэж шинэчлэн тогтоох гарцаагүй тулгамдсан асуудлын нэг болж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо "Шивээ-Овоо" хувьцаат компанийн 2014 оны батлагдсан эдийн засаг, зорилтот түвшингийн үндсэн үзүүлэлтүүд "хангалттай" биелсэн гэж дүгнэж байна.

"Шивээ-Овоо" ХК-ийн 2014 оны зорилтот түвшин, санхүүгийн тайлан тэнцлийн дүнгийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахад товчдоо ийм байна.

2 дугаар асуудал

Хэлэлцсэн нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлын тайланг сонсож үнэлэлт, дүгнэлт өгөх.

Тэмдэглэсэн нь:

Х.Ганцогт: Одоо Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлын тайлан зардлын гүйцэтгэл, 2015 оны зардлын төсвийн талаарх 2,3-р асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга танилцуулъя.

С.Одбаяр: Төлөөлөн удирдах зөвлөл нь 2014 оны 4-р сарын 29-ний өдрийн 05 тоот шийдвэрээр 10 гишүүнтэй болон болж ажиллаа. Компанийн 90-н хувийн хувьцаа эзэмшигч Эрдэнэс Монгол ХХК-ийг төлөөлж Эрдэнэс Монгол компанийн дэд захирал Б.Ариунболд, газрын захирал Э.Сэржбадам, ЭХЯ-ны ахлах мэргэжилтэн Д.Даваасүрэн, П.Энхцэлмэг, Уул уурхайн яамны газрын дарга Б. Батхүү нар ТУЗ-д ажилласан бол Хараат бус гишүүн 3, 10-н хувийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлийг хэрэгжүүлэхээр 1 гишүүн ажилласан.

ТУЗ нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд ТУЗ-ын хурлыг нийт 8 удаа зохион байгуулж, компанийн үйл ажиллагааны явц байдал, цаашид авах арга хэмжээний талаар гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүдийн илтгэл, тайлан, мэдээлэлийг 14 удаа сонсож 30-н тогтоол 8 тэмдэглэл гаргажээ. Хурлын ирц 66-100 хувь байсан ирц хүрээгүй шалтгаанаар хурал хойшилж байгаагүй болно.

ТУЗ-ын шийдвэр нь нийт 30 багц асуудлыг хамарсан бөгөөд эдгээр асуудлуудыг хэлэлцэн 26 үүргийг гүйцэтгэх удирдлага болон санхүү ЭЗ-ийн хэлтэст өгсөн бөгөөд 22 буюу 84,6 хувь нь бүрэн хэрэгжиж, 2 асуудал буюу 7,7 хувь нь хэрэгжих шатандаа, 2 асуудал буюу 7,7 хувь нь дутуу хэрэгжсэн байна.

24-р тогтоолоор шийдвэрлэгдсэн Нүүрс хатаах үйлдвэр болон конвейерийн тээврийн системийг салгаж ажиллуулах ажил хийгдэж дуусаагүй хэрэгжилтийн шатандаа мөн 26-р тогтоолоор шийдвэрлэгдсэн он дамжиж хэрэгжих "Тасралтгүй ажиллагаат технологи" нэвтрүүлэх ажил гэрээ хийгдсэн байдалтай хэрэгжих шатандаа явна.

Харин 5-р сарын 20-ны 16-р тогтоолын 2-р заалт болох "Хөрөнгүүдийг данснаас хасах үйл ажиллагаагаа хэрхэн зохион байгуулсан талаарх тайлангаа ТУЗ-д танилцуулах" гэсэн заалт хэрэгжсэнгүй. Мөн 2,5 тэрбум төгрөгийн зээлийн зарцуулалт эргэн танилцуулагдаагүй гээд нийт 2 тогтоол дутуу хэрэгжлээ.

2014 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан ТУЗ-ийн төлөвлөгөөгөөр 17-н асуудал хэлэлцэхээр батлагдснаас 12 асуудлыг хэлэлцэж 5-н асуудлыг хэлэлцсэнгүй.

ТУЗ-ын зардалд 44,0 сая төгрөг баталуулж төлөвснөөс 32,3 сая Төгрөг зарцуулж 26,0 хувь хэмнэжээ.

ТУЗ-ийн шуурхай оновчтой шийдвэрүүдийн үр дүнд компани төлөвлөгөөт алдагдлыг 976,9 сая төгрөгөөр хэмнэсэн. Эдгээрийг дурдвал:

Хөрс тээвэрлэлтийн зарим ажлыг оператор компаниар хямд гүйцэтгүүлэх шийдвэр гаргаснаар 745,0 сая төгрөг хэмнэсэн.

Түлш нийлүүлэх тендерийн гэрээг цуцалж дахин зарлах шийдвэр гаргаснаар 1831903 л литр дизелийн түлшийг 126.4 төгрөгөөр хямдаар худалдан авч 231,9 сая төгрөг хэмнэсэн.

Мөн “Белаз” машинаар парк шинэчлэл хийж эхлэх, “Тасралтгүй үйл ажиллагаат технологи” нэвтрүүлэх зэрэг компанид стратегийн ач холбогдолтой чухал шийдвэрүүдийг гаргаж ажилласныг дурдах нь зүйтэй.

Гэвч бүх юм хэвийн сайн шулуун байсангүй 2014 оны ТУЗ-ийн үйл ажиллагаанд анхаарч залруулбал зохих 2 дутагдал байсан бөгөөд эдгээрийг 2015 оноос эхлэн залруулж давтан гаргахгүй ажиллахыг зорьж байна.

Цаашид шийдвэрийн хэрэгжилтэнд анхаарах шаардлагатай байгаа тул ТУЗ-ийн хурал эхлэхэд өмнөх хурлаар шийдвэрлэсэн асуудлын биелэлтийг танилцуулдаг журамд шилжиж шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах болно. Дэд хороодын ажлын төлөвлөгөө байхгүй үйл ажиллагаа сул байгаа энэ байдалд дүгнэлт хийн 2015 оны 4-р сарын 28-нд батлагдах ТУЗ-ийг бүрэлдэхүүнээс дэд хороодыг шинэчилж томилон төлөвлөгөөг нь баталж үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.

3 дугаар асуудал

Хэлэлцсэн нь:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын гүйцэтгэлийг хэлэлцэх, 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хэлэлцэж батлах.

Тэмдэглэсэн нь:

С.Одбаяр: ТУЗ нь 2014 онд 44,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөгдснөөс 32,3 сая төгрөг зарцуулж 26,0 хувиар зардлаа хэмнэсэн гол хэмнэлт нь бол компанийн ТУЗ-ийн ажиллах журмын дагуу ТУЗ-ийн цалинг зөвхөн тухайн сарын хуралд оролцсон гишүүдэд олгож байсан үүнээс шалтгаалан цалингийн зардалд хэмнэлт гарсан. Мөн хоолны зардал гараагүй 2 удаа уурхай дээр очиж хуралдах байсан 1 удаа очсноос хэмнэлтүүд гарсан.

Одоо 2015 оны зардлын төсвийг танилцуулья. ТУЗ-ийн. Хурлыг УБ хотод 9 удаа компани дээр 2 удаа зохион байгуулна.

Манай ТУЗ-ийн нэг онцлого бол Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу буюу Төрийн өмчит ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн сарын цалин хуулиар батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс бага байна гэсэн

зарчим баримталж тогтоодог тул гишүүдийн цалин бага үүнийгээ дагаад ТУЗ-ийн зардал бусад компаниас бага байдаг.

ТУЗ нь дүрмийн дагуу 9 гишүүнтэй ажиллаж ТУЗ-ийн дарга сард 380,0, гишүүд 360,0 мянган төгрөгийн цалинтай байна. Нарийн бичгийн даргын УБ хотод ирэх буцах унааны зардал 240,0 мянган төгрөг, ТУЗ-ийн гишүүдийг 2 удаа уурхай дээр очих зардалд 860,0 мянган төгрөг зарцуулна. ТУЗ-ийн дэргэдэх 3 хорооны ажилд зориулж 1500,0 мянган төгрөг төлөвлөсөн. Ингээд ТУЗ-ийн нийт зардалд 50,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Энэ төсвийг баталж өгөхийг хүсч байна.

4 дүгээр асуудал

Хэлэлцсэн нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

Тэмдэглэсэн нь:

Б.Ариунболд: Манай компаниас Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшүүлэхдээ Ерөнхий сайд болон Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу ТУЗ-д төрийн оролцуулахгүй гэдэг зарчмыг баримталсныг хэлэх нь зүйтэй. Эрдэнэс Монгол ХХК нь төрийн компани боловч бизнесийн зарчимаар ажиллах болсон. Компанийн үйл ажиллагаанд төр их оролцохоор нүүрсний үнийг маань чөлөөлж өгөхгүй алдагдал гарахаас эхлээд олон хүндрэл үүсээд байдаг. Иймд компанийн менементийг өөрчлөхийн тулд ТУЗ-ийг Эрдэнэс Монголоос бүрдүүлж байгаа болно. Төрөөс бизнест чөдөр тушаа болохгүйн тул ТУЗ-ийг Эрдэнэс Монгол ХХК дангаараа аваад явья гэдэг зарчим баримталсан. Ингээд хуучин ТУЗ-ийг чөлөөлж, шинээр 5 гишүүн оруулж ирж байна. Үүнд Тэргүүн дэд захирал Б.Ариунболд, Дэд захирал С.Цэлмэг, уул уурхайн газрын захирал Д.Болд, мэргэжилтэн Ж.Батбаяр, төсөл хариуцсан захирал Ж.Төмөрпүрэв нарын 5 хүнийг нэр дэвшүүлж байгаа болно. Хуулийн дагуу манай ТУЗ-д хараат бус 3-н гишүүн байдаг, хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлаж 19 хүний материал ирсэн эдгээрийг судлаад Д.Батсүх, Д.Дондов, Ц.Цолмон нарын 3-н хүнийг сонгож нэрийг нь дэвшүүлж байна. Ингээд 8-н гишүүн ТУЗ-д сонгох саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна. Одоо хувийн эзэмшлийн 10-н хувийг төлөөлж ТУЗ-д ажиллах гишүүний танилцуулагыг нийт хувьцааны 8,47 хувийг эзэмшигч Жеймс Пастон танилцуулна.

Жеймс Пастон: Манай компанийн зүгээс Б.Пүрэвбаатарыг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлж байна. Б.Пүрэвбаатар 1986 онд төрсөн СЭЗДС төгсөж Чех улсад мастерийн зэрэг хамгаалсан Хөрөнгө оруулалтын чиглэлээр 6 жил ажилласан туршлагатай мэргэжилтэн юм. /орчуулагчийн шууд орчуулсныг тэмдэглэв./

5 дугаар асуудал:**Ногдол ашиг хувиарлахгүй тухай мэдэгдэл**

С.Одбаяр: Тус компани 2014 онд 4,9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр 2-р сарын 15-ны өдөр гарсан. Алдагдалтай ажиллаж байгаа шалтгаан нь 2014 онд манай компани 1 тонн нүүрсээ 20,3 мянган төгрөгөөр олборлож 17,9 мянган төгрөгөөр борлуулсан. Эрчим хүчний тухай хуулийн дагуу нүүрсний үнийг төрөөс ингэж өртгөөс нь доогуур тогтоож байгаа нь алдагдалтай ажиллах гол үндэс болж байгаа юм. Гэхдээ нөгөө өнцөгөөс нь харвал манайх алдагдалтай ажиллаж нүүрсний үнийг хямд байлгаснаар цахилгаан дулааны үнэ хямд байж, үнэ хямд байгасны үр өгөөжийг Монгол улсын 3-н сая иргэн 50 гаруй мянган аж ахуйн нэгж бүгд хүртэж байгаа болохоор манай компаний ногдол ашгийг улс даяараа хүртдэг гэж хэлж болно.

Хэлэлцсэн асуудалтай холбогдсон асуулт хариулт санал

Х.Ганцогт: Одоо хэлэлцсэн асуудалтай холбогдуулан хувьцаа эзэмшигчид компанийн удирдлагуудад асуулт тавиад саналаа хэлэх зарчимаар хурлаа үргэлжүүлье.

Ц.Чимгээ: Надад 3-н асуулт байна. 1. Хөрөнгийн биржийн сайтанд байрлуулсан танай санхүүгийн тайлан энэ хурлын материалд тараагдсан тайлан 2 яагаад зөрүүтэй байна вэ?

2. Шивээ сервис ХХК-ийн талаар танилцуулна уу тайлан нь энд нэгтгэгдээгүй юм байна.

3. 2015 онд хэдэн тонн нүүрс борлуулахаар төлөвлөсөн бэ?

С.Одбаяр: Эхний асуултанд хариулья. Манай компани 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2015 оны 2-р сарын 7-нд гаргаж хөрөнгийн биржийн сайтанд байршуулсан. Үүний дараа Балхан аудит ХХК санхүүгийн тайланд аудит хийхдээ тодорхой зөвлөмжүүдийг өгч энэ дагуу тайлан залруулагдсан байгаа. Хувьцаа эзэмшигчдэд тараасан тайлан нь аудитын зөвлөмж туссан зөв тайлан одоо энэ тайланг Хөрөнгийн биржийн сайтанд дээр засаж байрлуулна.

О.Отгонбаатар: Шивээ сервис ХХК нь манай компанийн ажилчдын хоол, орон сууцны үйлчилгээ ажлын хувцас угаалга зэргийг хариуцан ажилладаг манай компанийн охин компани. 2015 оны 3-р сард тус компанийн алдагдлыг бууруулах, бүтцийг сайжируулах санал ТУЗ-өөр хэлэлцүүлж үүрэг аваад менежмент удирдлагыг багийг сайжруулан ажиллаж байгаа. Санхүүгийн тайланг нь энэ оны эхний улирлаас нэгтгэнэ.

2015 онд Шивээ-Овоо ХК нь 2,3 сая тонн нүүрс борлуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Амгалангийн дулааны станц төлөвлөсөн хугацаандаа ашиглалтанд

ороогүйгээс энэ төлөвлөгөө маань тасрах эрсдэл үүсээд байгаа гэхдээ бид аль болох биелүүлэхийн төлөө ажиллах болно.

М.Банзар: Надад асуулт бас санал байна. Өнгөрсөн жилийн хурал дээр би Герман улсад сурч байхдаа судалсан туршлагаа ярьж шахмал түлшний үйлдвэр байгуулаач гэдэг саналаа тавьсан энэ юу болсон бэ? Хаа сайгүй нүүрсний уурхай гараад байгаа энэ үед нүүрсээ зүгээр зараад ашигтай ажиллана гэж байхгүй, шахмал түлш хийх, эсвэл угааж экспортлох 3 дахь нь дэргэд нь станц байгуулах гэсэн 3-н арга л байна. Зээл энэ тэр аваад эдгээр аргуудыг л хэрэгжүүлэх арга хэмжээ авмаар байна.

О.Отгонбаатар: Манай нүүрсийг угаах боломж байхгүй харин бид хатаах үйлдвэрээ боловсронгуй болгох чиглэлээр тендер зарлаад ажиллаж байна. Харин шахмал түлшний үйлдвэрийн ажил эхлэсэн барилга байшинг нь засаад бэлтгэсэн одоо 5-р сард тоног төхөөрөмж нь орж ирээд 6-р сард суурьлагдаж ажил нь эхлэнэ. Ингэсээр 1-рт компани нэмэгдэл орлого олох 2-рт Улаанбаатар хотын утааг багасгах гэсэн 2 ач холбогдолтой ажил болно.

М.Банзар: Саналыг маань хүлээн авч хэрэгжүүлсэнд их баяртай байна. Урьд Шивээ Овоод энэ хурлыг хийдэг байхад бид очиж чаддаггүй байсан энд хийснээр бид оролцох боломжтой болсныг энд хэлэх нь зүйтэй байх.

А.Чулуун: Улаанбаатар хотод хурал хийж хувьцаа эзэмшигчдээ том жижиг гэж ялгалгүй оролцуулж санал бодлыг нь сонсож байгаад талархаж байна. Эдийн засагч хүний хувьд би алдагдалтай ажиллаад байгааг ойлгож байна алдагдлыг улсаас татаас хэлбэрээр нөхөж өгдөг үү? Нүүрсний бодит өртөг зардлаа гаргаж танилцуулаад төр засагтайгаа ойлголцоод алдагдалгүй ажиллах арга байна уу?

О.Отгонбаатар: Бидний зүгээс нүүрсний өртөг ийм өнлөр байна шүү үнийг энд нь хүргэж нэмэгдүүлнэ үү гэдэг санал хүсэлтийг яам, эрчим хүчний зохицуулах хороо Засгийн газарт байнга тавьдаг. 2013 оны 8-р сард 3000 төгрөгөөр, 2015 оны 1-р сарын 1-нээс мөн 3000 төгрөгөөр нэмж өгсөн гэхдээ энэ нэмэгдэл хангалтгүй байгаа дахиад ч нэмэгдүүлэх индексжүүлэх шаардлагатай байна гэсэн хүсэлтээ бид гаргачихаад байгаа 7-р сарын 1-нээс үнэ чөлөөлөх асуудлыг Засгийн газар хөндөөд эхлэсэн байна. Энэ хэрэгжвэл манай компанид чухал ач холбогдолтой шийдвэр болох юм. Өмнө нь 2012 оны УИХ-ийн 72-р тогтоол гарч 2014 оноос эрчим хүчний үнийг чөлөөлөхөөр тусгасан боловч хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй байгаагын шалтгаан нь нүүрсний үнийг чөлөөлвөл цахилгаан дулааны үнэ өсч үүнийг дагаад бүх өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэн ард иргэдийн амьдралд нөлөөлнө гэж болгоомжилсонтой холбоотой гэж бодож байна.

Х.Ганцогт: Хэлэлцсэн асуудлууд болоод тогтоолын төслүүдийн талаар хувьцаа эзэмшигчдэд өөр санал байна уу? Татгалзаж түтгэлзсэн хүн байна уу?

Хэлэлцсэн асуудал тус бүрийг дахин танилцуулж батлуулав. Хувьцаа эзэмшигчдээс өөр санал гарсангүй.

Х.Ганцогт: Өөр санал байхгүй бол 4-н асуудалтай холбогдон гарах тогтоолын төслүүдийг батлах уу? Саналын хуудсаа бөглөөд тооллогын комисст өгье тооллогын комисс дүнг нэгтгээд танилцуулна.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100 хувь батлах саналтай байв.

Д.Болд: “Шивээ-Овоо” ХК-ийн хуралд оролцох эрх бүхий нийт 1644 хувьцаа эзэмшигчдээс Төрийн өмчийн 90 хувийг төлөөлж 3, хувийн өмчийн 10 хувийг төлөөлж 4 хувьцаа эзэмшигч өнөөдрийн хуралд оролцож 15 саналын хуудсаар санал хураав.

Саналын хуудсыг тоолоход хүчинтэй саналын хуудас 15 байлаа.

1. 2014 оны санхүүгийн тайлан тэнцэлийг батлах тухай тогтоолын төслийг батлахыг зөвшөөрсөн 100 хувь,

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны тайлангийн тухай тогтоолын төслийг батлахыг зөвшөөрсөн 100 хувь,

3. 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах тухай тогтоолын төслийг батлахыг зөвшөөрсөн 100 хувь байна.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудлаар саналын хуудсаар кумулятив аргаар санал хураалт явуулахад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч

Б.Ариунболд 14493093санал, С.Цэлмэг 14492943 санал, Д.Болд14492943 санал, Ж.Батбаяр14492943 санал, Төмөрпүрэв14492943 санал, Д.Батсүх 13214927 санал, Д.Дондов 13214952 санал, Ц.Цолмон 12077453 санал, Б.Пүрэвбаатар 6825098 санал, Д.Баярсайхан 1137449 санал тус тус авсан байна.

Олонхийн санал авсан Б.Ариунболд, С.Цэлмэг, Д.Болд, Ж.Батбаяр, Ж.Төмөрпүрэв, Б.Пүрэвбаатар нарыг ердийн,Д.Батсүх, Д.Дондов, Ц.Цолмон нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгох саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна.

Хурлаас гаргасан шийдвэрүүд

Х.Ганцогт: Хурлын дэгийн дагуу одоо хурлаас гарах тогтоолын төслүүдийг уншиж сонсоё.

1-р тогтоол 2014 оны тайлан тэнцлийг батлах тухай.

Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлт, Балхан-Аудит ХХК-ийн гаргасан хараат бус аудитын дүгнэлт зэргийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1.Шивээ овоо ХК-ийн 2014 оны жилийн эцсийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг 96094.3 сая төгрөгөөр Үүнээс: Эргэлтийн хөрөнгийг 26191.2 сая төгрөгөөрб/ Биет үндсэн хөрөнгийг 68476.5 сая төгрөгөөр в/ Биет бус хөрөнгийг 579.6 сая

төгрөгөөр г/ Урт хугацаат хөрөнгө оруулалтыг 946.9 сая төгрөгөөр
 Өр төлбөр эзэмшигчдийн өмчийн дүнг 96094.3 сая төгрөгөөр Үүнээс: г/ Урт
 хугацаат өр төлбөрийг 55378.9 сая төгрөгөөр д/ Төрийн өмчийн дүнг 1207.7 сая
 төгрөгөөр е/ Эзэмшигчдийн өмчийн бусад хэсгийг 20329,4 сая төгрөгөөр ё/
 Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүнг 134.2 сая төгрөгөөр ж/ Богино хугацаат өр
 төлбөрийг 31271.1 сая төгрөгөөрз/ Хуримтлагдсан алдагдлыг 7240.7 сая төгрөгөөр
 и/ Тайлант үеийн алдагдлыг 4986.3 сая төгрөгөөр тус тус баталсугай.

2-р тогтоол Төсөв батлах тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан
 компанийн 2015 бизнес төлөвлөгөөг үндэслэн ТОГТООХ НЬ:

1."Шивээ-Овоо" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын
 төсвийг 50 097,6 мянган төгрөгөөр тогтоож хавсралтын дагуу баталсугай.

2.Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулахыг Төлөөлөн Удирдах
 Зөвлөл д үүрэг болгосугай.

3-р тогтоол 2014 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг батлах тухай

Шивээ Овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны
 ажлыг тайланг үндэслэн ТОГТООХ НЬ:

1."Шивээ-Овоо" ХК-ийн Санхүүгийн үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах
 зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг зөвшөөрч, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны
 үйл ажиллагааг "хангалттай" гэж дүгнэсүгэй.

2.Компанийн алдагдлыг бууруулах, бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх, өр
 авлагыг барагдуулах талаар дэмжлэг үзүүлж, удирдлагаар ханган ажиллахыг
 Төлөөлөн удирдах зөвлөл / Ж.БАТБОЛД /-д үүрэг болгосугай.

4-р тогтоол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62,1,7 дахь заалтын дагуу, 2012 оны 4 дүгээр
 сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 1
 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийг
 төлөөлөх гишүүдийг 1 дүгээр хавсралтын дагуу, хараат бус гишүүдийг 2
 дугаар хавсралтын дагуу 2015 оны 5 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн
 сонгосугай.

Хурлын хаалт

*Тогтоолын төслүүдийг нэг бүрчлэн батлаж дуусгасны дараа хурлыг хааж
 Эрдэнэс Монгол ХХК-ийн Тэргүүн дэд захирал Б.Ариунболд үг хэлэв.*

Б.Ариунболд: Одоо редакцийн комисс ажиллаж тогтоолуудаа бэлэн
 болгоорой. Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид болон компанийн
 удирлагын багт хурал амжилттай болсныг тохиолдуулан баяр хүргэж 2015 оны

ажилд нь амжилт хүсье. Мөн шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлд баяр хүргэж компанийг ашигтай ажиллах түвшинд хүргэх боломж олгож ажиллахыг хүсье. Ингээд "Шивээ-Овоо" хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаа хаасныг мэдэгдэж байна.

Хурал 12 цаг 10 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Х.ГАНЦОГТ

О.ЧИНХҮСЭЛ

“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр сарын 28-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

2014 оны тайлан тэнцлийг батлах тухай

Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлт, Балхан-Аудит ХХК-ийн гаргасан хараат бус аудитын дүгнэлт зэргийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Шивээ овоо ХК-ийн 2014 оны жилийн эцсийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг 96094.3 сая төгрөгөөр

Үүнээс:

- а/ Эргэлтийн хөрөнгийг 26191.2 сая төгрөгөөр
- б/ Биет үндсэн хөрөнгийг 68476.5 сая төгрөгөөр
- в/ Биет бус хөрөнгийг 579.6 сая төгрөгөөр
- г/ Урт хугацаат хөрөнгө оруулалтыг 946.9 сая төгрөгөөр

Өр төлбөр эзэмшигчдийн өмчийн дүнг 96094.3 сая төгрөгөөр

Үүнээс:

- г/ Урт хугацаат өр төлбөрийг 55378.9 сая төгрөгөөр
- д/ Төрийн өмчийн дүнг 1207.7 сая төгрөгөөр
- е/ Эзэмшигчдийн өмчийн бусад хэсгийг 20329,4 сая төгрөгөөр
- ё/ Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүнг 134.2 сая төгрөгөөр
- ж/ Богино хугацаат өр төлбөрийг 31271.1 сая төгрөгөөр
- з/ Хуримтлагдсан алдагдлыг 7240.7 сая төгрөгөөр
- и/ Тайлант үеийн алдагдлыг 4986.3 сая төгрөгөөр

тус тус баталсугай.

ХУРЛЫН ДАРГА -

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Х.ГАНЦОГТ

О.ЧИНХҮСЭЛ

**“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төсөв батлах тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 01 дүгээр тогтоолоор
батлагдсан компанийн 2015 бизнес төлөвлөгөөг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1.“Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын
төсвийг 50 097,6 мянган төгрөгөөр тогтоож хавсралтын дагуу баталсугай.

2.Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулахыг Төлөөлөн Удирдах
Зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Х.ГАНЦОГТ

О.ЧИНХҮСЭЛ

“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2015 оны 4-р сарын 28-ны өдрийн 02 тоот
тогтоолын хавсралт

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын төсөв

Д/д	Зардлын төрөл	Хэмж их нэгж	2014 оны		Биелэлт %	2015 оны Төлөвлөг өө
			төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	Цалин хөлс НДШ	м.төг	38,126.2	24,980.0	0.66	44,205.6
2	Унааны зардал	м.төг	1,100.0	126.4	0.11	1,100.0
3	Хоолны зардал	м.төг	600.0	-	-	600.0
4	Томилолт	м.төг	192.0	350.0	-	192.0
5	Сургалт	м.төг	1,500.0	-	-	1,500.0
6	Бичиг хэрэг	м.төг	1,000.0	97.0	0.11	1,000.0
7	Хувьцаа эзэмшигчдийн хурал бүртгэл судалгаа	м.төг	-	6,959.8		
8	Бусад	м.төг	1,500.0	289.3	0.19	1,500.0
	Зардлын дүн	м.төг	44,018.2	32,365.2	0.74	50,097.6
	Гишүүд	хүн	9	10		9

**“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

2014 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн
тайланг батлах тухай

Шивээ Овоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлыг тайланг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.“Шивээ-Овоо” ХК-ийн Санхүүгийн үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг зөвшөөрч, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.Компанийн алдагдлыг бууруулах, бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах талаар дэмжлэг үзүүлж, удирдлагаар ханган ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Х.ГАНЦОГТ

О.ЧИНХҮСЭЛ

“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг
сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62,1,7 дахь заалтын дагуу, 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 1 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх гишүүдийг 1 дүгээр хавсралтын дагуу, хараат бус гишүүдийг 2 дугаар хавсралтын дагуу 2015 оны 5 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Х.ГАНЦОГТ


~~О.ЧИНХҮСЭЛ~~



Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 4-р сарын 28-ний өдрийн хурлын 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

“Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх гишүүд

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил
1	Б.Ариунболд	Эрдэнэс Монгол ХХК-ийн Тэргүүн дэд захирал
2	С.Цэлмэг	Эрдэнэс Монгол ХХК-ийн дэд захирал
3	Д.Болд	Эрдэнэс Монгол ХХК-ийн уул уурхайн бодлого, төсөл хөтөлбөрийн багийн захирал
4	Ж.Батбаяр	Эрдэнэс Монгол ХХК-ийн уул уурхайн бодлого, төсөл хөтөлбөрийн багийн дэргэдэх худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
5	Ж.Төмөрпүрэв	Эрдэнэс Монгол ХХК-ийн уул уурхайн бодлого, төсөл хөтөлбөрийн багийн захирал
6	Б.Пүрэвбаатар	Firewird компанийн газрын дарга



**“Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүд**

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил
1	Д.Батсүх	Тэтгэвэрт
2	Д.Дондов	Тэтгэвэрт
3	Ц.Цолмон	Эрхзүйч

**“Шивээ-Овоо” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын тооллогын комиссын тэмдэглэл**

2015 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Шивээ-Овоо” ХК-ийн хуралд оролцох эрх бүхий нийт 1644 хувьцаа эзэмшигчдээс Төрийн өмчийн 90 хувийг төлөөлж 3, хувийн өмчийн 10 хувийг төлөөлж 4 хувьцаа эзэмшигч өнөөдрийн хуралд оролцож 15 саналын хуудсаар санал хураав.

Саналын хуудсыг тоолоход хүчинтэй саналын хуудас 15 байлаа.

1. 2014 оны санхүүгийн тайлан тэнцэлийг батлах тухай тогтоолын төслийг батлахыг зөвшөөрсөн 100 хувь,

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны тайлангийн тухай тогтоолын төслийг батлахыг зөвшөөрсөн 100 хувь,

3. 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах тухай тогтоолын төслийг батлахыг зөвшөөрсөн 100 хувь байна.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудлаар саналын хуудсаар кумулятив аргаар санал хураалт явуулахад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч

Б.Ариунболд 14493093 санал, С.Цэлмэг 14492943 санал, Д.Болд 14492943 санал, Ж.Батбаяр 14492943 санал, Төмөрпүрэв 14492943 санал, Д.Батсүх 13214927 санал, Д.Дондов 13214952 санал, Ц.Цолмон 12077453 санал, Б.Пүрэвбаатар 6825098 санал, Д.Баярсайхан 1137449 санал тус тус авсан байна.

Олонхийн санал авсан Б.Ариунболд, С.Цэлмэг, Д.Болд, Ж.Батбаяр, Ж.Төмөрпүрэв, Б.Пүрэвбаатар нарыг ердийн, Д.Батсүх, Д.Дондов, Ц.Цолмон нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгох саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна.


ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

ГИШҮҮД

Д.БОЛД

Г.БОРГИЛ

Д.ГАНБААТАР



2015 оны 04 сарын 27 өдөр

Дүгээр 19

Төлөөлөгчийн

**Хувьцаа эзэмшигчийн төлөөлөгчийг
томилж, удирдамж батлах тухай**

Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.18-д заасныг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. "Шивээ-Овоо" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 4 дүгээр сарын 28-ний өдөр болох ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчийн төлөөлөгчөөр "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Х.Ганцогт /хурал даргалагч/, Ж.Бат-Эрдэнэ, Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан нарыг томилж, түүний баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэлийг сайтар ханган, зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, "Шивээ-Овоо" ХК-ийн гүйцэтгэх захирал О.Отгонбаатар нарт даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Тамирт даалгасугай.

ДАРГА



Ш.СОЛОНГО

“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Шивээ Овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10 цагт хуралдаж доорхи асуудлуудыг хэлэлцэнэ.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлын тайланг сонсож үнэлэлт, дүгнэлт өгөх.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын гүйцэтгэлийг хэлэлцэх, 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хэлэлцэж батлах.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
5. Нэгдэл ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаарх мэдээлэл хийх.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийн 2015 оны 3-р сарын 30, эчнээгээр санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 4-р сарын 28-ны өдрөөр тус тус тасалбар болгоно. Хувьцаа эзэмшигчид та бүхэн харьяа брокер диллерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан хуралдаа идэвхтэй оролцоно уу.

Хурал хуралдах газрын хаяг:

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 18-р хороо,
Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж-23/1,
Багануур ХК-ийн Төлөөлөгчийн газрын байрны 101 тоот өрөө
Шивээ-Овоо ХК-ийн Төлөөлөгчийн газарт

Лавлах утас: Утас: 458940, 95660389,
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2015-03-20

Тендер шалгаруулалтын нэр: Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 15 дугаар хорооллын шинээр баригдах УДДТөв-376-гийн 1, 2 дугаар хэлхээний гадна дулаан, усны шугам зөөж угсрах, зам талбайн ажиг

Тендер шалгаруулалтын дугаар: ОСНААУГ-15/013

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар нь эрх бүхий тендер оролцогчдоос "Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 15 дугаар хорооллын шинээр баригдах УДДТөв-376-гийн 1, 2 дугаар хэлхээний гадна дулаан, усны шугам зөөж угсрах, зам талбайн ажиг"-ыг гүйцэтгэх тухай битүүлжигийг тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн Баримт бичгийг (хүснэл номлолт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 100000 лэг зуун мянган / төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2013, 2014 онуудын дундаж борлуулалтын орлого 226.0 сая төгрөгөөс багагүй байна.

Түргэн хөрөөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Тендер оролцогчийн ирүүлсэн үнийн саналын 30 %-аас багагүй

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2013, 2014 он Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2013, 2014 онуудад дор хаяж нэг удаа 136.0 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажиг гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: шаардлагатай. Барилга хот байгуулалтын яамны 2.2.1 - Барилгын дотор халсаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралтын ажлын өсхүл 2.2.4 – Дулааны болон усан хангамжийн гол / магистраль шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралтын ажлын болон Эрдэс баялаг эрчим хүчний яамны 03.5.2 - 0.7-40.0 хэлсэ 2 Даралттай шугам хоолойн засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажиг үйлчилгээ эрхлэх холбогдох тусгай зөвшөөрлүүдийн аль нэг нь байж болно.

Тендерийн хамт 4508000 /дөрвөн сая таван зуун найман мянган/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2015 оны 4-р сарын 21-ний өдрийн 14 цаг 00 минутаас өмнө доорхи хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2015 оны 4-р сарын 21-ний өдрийн 14 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер оролцох эрхгүй.

Дэвүү эрхийн зөрүү тооцохгүй.

Төлбөр хийх хэлбэр: Тендерийн бичиг баримтын төлбөрийг дансаар тушаана.

Банкны нэр: Төрийн банк

Дансны дугаар: 102100001165

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын байр, 4 дүгээр давхар, 403 тоот, Нягтлан бодогч Н.Баасансүрэн, Утас: 7011-1404, 7011-1756

B2 | 2015 оны гуравдугаар сарын 20

"ШИВЭЭ-ОВОО" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Шивээ Овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10 цагт** хуралдаж доорхи асуудлуудыг хэлэлцэнэ.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлын тайланг сонсож үнэлэлт, дүгнэлт өгөх.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын гүйцэтгэлийг хэлэлцэх, 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хэлэлцэж батлах.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
5. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаарх мэдээлэл хийх.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2015 оны 3-р сарын 30**, эчнээгээр санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг **4-р сарын 26-ны** өдрөөр тус тус тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигчид та бүхэн харьяа брокер дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан хуралдаа идэвхтэй оролцоно уу.

Хурал хуралдах газрын хаяг:

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж-23/1, Багануур ХК-ийн Төлөөлөгчийн газрын байрны 101 тоот өрөө "Шивээ-Овоо" ХК-ийн Төлөөлөгчийн газарт

Лавлах утас: Утас: 458940, 95660389
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

СУРТАЛЧИЛГАА

Х-ийн ГЧДИЙН Н ЗАР

4 дэх заалт, Санхүүгийн
н 34-р хураам-ын 3.2 болон
цаа эзэмшигчдийн ээлжит

гийн тайлан, (аудитаар

йланг хэлэлцэж дүгнэлт

гох, батлах тухай
төсвийг батлах тухай

13-ний өдрийн 18 цагаар
4-р сарын 28-ний өдрийн
дэхдээ
дөхтэй оролцох, саналаа

УУЛАХ КОМИСС

ИЛГА

хорооллын 43 дугаар байрны халаалтын

дээрх "Белен дүүрэг, 17 дугаар хороо,
д" -ыг гүйцэтгэх тухай бичүүлж илсэн

дээрх эрх зөвлөхгүй нөхцөлтэйгээр
Төндөр нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45

д хангасан байна. Үүнд:

2 жил буюу 2013, 2014 онуудын дундаж

дээс Төндөр оролцогчийн ирүүлсэн үнийн

Сүүлийн 2 жил буюу 2013, 2014 он
2014 онуудад дор хаяж нэг удаа 45,0 сая

дээрх агаартай. Бөриг хот байгуулалтын
татуурлын шугам сүлжээ, тэдгээрийн тоног,
И - Дулааны болон усан хангамжийн гол /
н болон Эрдэс баялаг эрчим хүчний яамны
түүний туршилт тохируулга, дагалдах ажл
дээ.

д / төгрөгийн дүнтэй төндөрийн баталгаа

дээрх хялгар ирүүлэх ба нээлтэд оролцох
н 21-ний өдрийн 14 цаг 30 минутад нээнэ.

р тушаана.

“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Шивээ Овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4 дүгээр сарын
28-ны өдрийн 10 цагт хуралдах доорхи асуудлуудыг хэлэлцэнэ...

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх.
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлын тайланг сонсож үнэлэлт, дүгнэлт
өгөх.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын гүйцэтгэлийг хэлэлцэж,
2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хэлэлцэж батлах.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
5. Ногдол айлыг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн
талаарх мэдээлэл хийх.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн
өдрийг 2015 оны 3-р сарын 30, эцэсгээр санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын
хуудсыг хүлээн авах сүүтчийн өдрийг 4-р сарын 26-ны өдрөөр тус тус тасалбар болгоно.
Хувьцаа эзэмшигчид та бүхэн харьяа брокер диллерийн компани дээрээ очиж хурлын
материалтай танилцан хуралдаа идэвхтэй оролцоно уу.

Хурал хуралдах газрын хаяг:
Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 18-р хороо,
Мянлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж-23/1,
Багануур ХК-ийн Төлөөлөгчийн газрын байрны 101 тоот өрөө
/Шивээ-Овоо ХК-ийн Төлөөлөгчийн газарт

Лавлах утас: Утас:458940, 95660399,
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2015-03-20

Тендер шалгаруулалтын нэр: Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 15 дугаар хорооллын шивээр баригдах УДДТее-
376-гийн 1, 2 дугаар хэсгээр гадна дулаан, усны шугам зөвж угсрах, зам талбайн ажл

Тендер шалгаруулалтын дугаар: ОСНААУГ-15/013

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар нь эрх бүхий тендэрт оролцогчдоос "Баянзүрх дүүрэг, 7 дугаар
хороо, 15 дугаар хорооллын шивээр баригдах УДДТее-376-гийн 1, 2 дугаар хэсгээр гадна дулаан, усны шугам
зөвж угсрах, зам талбайн ажл"-ыг гүйцэтгэх тухай бичүүлж илсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эрх зөвлөхгүй нөхцөлтэйгээр
илж бүрдлээр нь 100000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн
45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендэрт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2013, 2014 онуудын дундаж борлуулалтын орлого 226,0 сая
төгрөгөөс багагүй байна.

Түргэн хөрөөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Тендэрт оролцогчийн ирүүлсэн үнийн
саналын 30 %-аас багагүй

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2013, 2014 он
Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2013, 2014 онуудад дор хаяж нэг удаа 136,0 сая
төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажл гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх шаардлагатай. Барилга хот байгуулалтын
яамны 2.2.1 - Берилгын дотор халаалт, салхиныг, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног,
техөөрмөл, гадна салбар шугам сүлжээний угсралтын ажлын эсхүл 2.2.4 - Дулааны болон усан хангамжийн гол /
магистралыг/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралтын ажлын болон Эрдэс баялаг эрчим хүчний яамны
03.5.2 - 0.7-40.0 кг/см 2 даралттай шугам хоолойн засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажл
үйлчилгээ эрхлэх холбогдох тусгай зөвшөөрлүүдийн аль нэг нь байх болно.

Тендерийн хамт 4508000 /дөрвөн сая таван зуун найман мянган/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа
ирүүлнэ.

Тендерийг 2015 оны 4-р сарын 21-ний өдрийн 14 цаг 00 минутас өмнө доорхи хаягаар ирүүлэх ба нээлтэд
оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан тендерийг 2015 оны 4-р сарын 21-ний өдрийн 14 цаг 30 минутад
нээнэ.

Гадаадын этгээд тендэрт оролцох эрхгүй.
Давуу эрхийн зөрүү тооцожгүй.
Тендер хийх хэлбэр: Тендерийн бичиг баримтын төлбөрийг дансаар тушаана.
Банкны нэр: Төрийн Банк
Төрийн банкны хаяг: 102100001155

ШИВЭЭ ОВОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2015 оны 2 дугаар
сарын ..15..-ны өдөр

№ .05

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 5 дугаар заалт, Балхан-Аудит компанийн баталгаажуулсан 2014 оны Санхүүгийн тайлан тэнцэл зэргийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Тус компани нь 2014 онд 4986313.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2.Ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ж.БАТБОЛД /-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ДАРГА



Ж.БАТБОЛД